




**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Нутгийн удирдлагын ордон, Уртоулаг баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621
Цахим шуудан: info@ordenet.mn

2023. 03. 22 № 029/670
танай _____ -ны № _____ -т

**ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ
ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН
АЖЛЫН АЛБАНД**

Орхон аймгийн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Орхон аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийг шинэчлэн байгуулсан аймгийн Засаг даргын 2023 оны А/50 дугаар захирамжийг тус тус хүргүүлэв.
Хавсралт ...!!...хуудастай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ  А. ТҮВШИНЖАРГАЛ



6123020653



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/50

Базин-Өндөр сум

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын
санаачилгын дэд зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоолын 11.2 дахь заалт, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар баталсан "Дэд зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг орон нутагт хангах ажлыг удирдан зохион байгуулах, салбарын засаглалын ил тод байдал, хариуцлагыг сайжруулах үүрэг бүхий Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийг хавсралтаар баталсугай.
2. Дэд зөвлөлийг нэгдсэн удирдлагаар хангаж, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг дэд зөвлөлийн дарга (А.Түвшинжаргал)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/148 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын 2023 оны
02 дүгээр сарын 09-ны өдрийн
150 дугаар захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: А.Түвшинжаргал (Аймгийн Засаг даргын орлогч)
- Гишүүд:
- С.Даваадорж (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
 - Б.Баасансүрэн (Баян-Өндөр сумын Засаг дарга)
 - Б.Энхжин (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн Төсвийн орлого, хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн)
 - С.Дуламсүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл Мэдээллийн ажилтан)
 - О.Цэрэнчимэд (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвлий, түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны бодлогын хэрэгжилт, хяналт шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн)
 - Д.Сүхбат (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын улсын ахлах байцаагч)
 - С.Цэвэл (Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн Нягтлан бодогч)
 - Л.Цэдэнсодном (Ачит Ихт ХХК-ийн Үйлдвэрийн захиргааны менежер)
 - Ч.Өлзийбүрэн (Эрдмин ХХК-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин хариуцсан ажилтан)
 - Т.Энхтуяа (ОТК ХХК-ийн Үйлдвэр, техникийн хэлтсийн инженер)
 - М.Ганбат (Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга)
 - Ж.Баярсайхан ("Монголын байгаль орчныг хамгаалах холбоо"-ны Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Байгаль орчныг хамгаалах салбар зөвлөл" ТББ-ын тэргүүн)
 - Б.Батцэцэг (Эрдэнэт хүмүүний эв нэгдэл ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга)
 - Б.Аюуш (Төр иргэн түншлэл ТББ-ын тэргүүн)
 - Ч.Энх-Амгалан (Говил багийн иргэн)
- Нарийн бичгийн дарга: У.Чигэстэй (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчин, уул уурхай хариуцсан хэлтсийн мэргэжилтэн)

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ
А. ТҮВШИНЖАРГАЛ

ОРХОН АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Санхүүжилт /сая. төг/	Хүрэх үр дүн
1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Судалгаа, мэдээ, тайлан гаргах						
1.	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээллийн сан бүрдүүлэх	Жилдээ	Аймгийн ЗДТГ ХБТХОХ	БОАЖГ, ГХБХБГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ	-	Мэдээллийн сантай болсон байна.
2.	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын мэдээ гаргах	Жилдээ	МХГ	Аймгийн ЗДТГ	-	Мэдээг тогтмол авсан байна.
3.	Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив, дэмжлэгийн мэдээ гаргах	Улирал, жилээр	Аймгийн ЗДТГ СТСХ	Татварын хэлтэс, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ	-	Иргэдэд ил тод мэдээлэх сайжирсан байна.
4.	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖСайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу гүйцэтгүүлж, батлуулан хэрэгжилтийг хангуулж ажиллах	Жилдээ	БОАЖГ	ХБТХОХ, МХГ, ГХБХБГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ	-	Байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл буурна.
5.	Уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөллийн бүсэд амьдарч байгаа айл ерх, иргэд, мал сүрэгт аюултай хог хаягдал, агаарын бохирдол, бусад сөрөг нөлөөллөөс үүсч буй хор хөнөөлийн талаарх мэдээ, судалгаа гаргах	Жилдээ	БОАЖГ, ЭМГ, МХГ, Стандарт хэмжил зүйн хэлтэс	Аймгийн ЗДТГ, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд, "Эрдэнэт хүмүүний эв нэгдэл" ТББ, "Төр иргэн түншлэл" ТББ, иргэд	-	Судалгааны сан бий болсон байна.
Зорилт 2. Тайлан мэдээг иргэдэд нээлттэй, ил тод мэдээлэх						

7.	Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурвалжлага, мэдээ явуулах	Жилдээ	Хэвлэл мэдээллийн байгууллагууд, "Эрдэнэт хүмүүний нэгдэл" ТББ, "Төр иргэн туншлал" ТББ	Аймгийн ЗДТГ, МХГ, БОАЖГ	-	Мэдээлэл нийтэд хүрсэн олон байна.
Зорилт 3. Хамтын ажиллагаа, түншлэл хөгжүүлэх, оролцогч талуудын чадавх бэхжүүлэх						
8.	Орхон аймаг, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Ачит-Ихт" ХХК, "Эрдмин" ХХК-тай байгуулсан хамтран ажиллах гэрээ, түүний хэрэгжилтийн тайланг нээлттэй тайлагнах	Жилдээ	Аймгийн ЗДТГ	Хэвлэл мэдээллийн байгууллагууд, "Эрдэнэт хүмүүний эв нэгдэл" ТББ, "Төр иргэн туншлал" ТББ	-	Хамтран ажиллах гэрээнд иргэдийн зүгээс тавих хяналт, мэдээлэл сайжирч, холбогдох мэдээллээр хангагдана.
9.	Хуульд заасан мэдээллийг үнэн зөв гаргаж нийтэд мэдээлээгүй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, тэдний гэрээт туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжид зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх	Жилдээ	МХГ	Аймгийн ЗДТГ	-	Мэдээллийг үнэн зөв мэдээлсэн байна.
10.	Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутгийн төсөвт 2023 онд төлж байгаа татвар, төлбөр, хураамж, торгууль зэрэг орлого болон аймаг, сумын ЗДТГ, төсөвт байгууллагад хандивлаж байгаа мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийн тайланг холбогдох маягтын дагуу жил бүр гаргаж нийтэд мэдээлэх, журмын дагуу тайлагнах	4-р улиралд	Аймгийн ЗДТГ СТСХ	Татварын хэлтэс, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд	-	Мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь мэдээлсэн байна.
11.	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, дэд зөвлөлийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	Жилдээ	Аймгийн ЗДТГ	МХГ, БОАЖГ	-	Үйл ажиллагааны хяналт сайжирна.
12.	Жил бүрийн ажлын төлөвлөгөө, тайланг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын албанд хүргүүлэх	Жилдээ	Аймгийн ЗДТГ	ОУИТБС-ын дэд зөвлөл	-	Төлөвлөгөө, тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна.

ОРХОН АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Санхүүжилт /сая.төг/	Хүрэх үр дүн	Биелэлт
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1. Судалгаа, мэдээ, тайлан гаргах							
1.	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээллийн сан бүрдүүлэх	Жилдээ	Аймгийн ЗДТГ ХБТХОХ	БОАЖГ, МХГ, ГХБХБГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ	-	Мэдээллийн сантай болсон байна.	Орхон аймгийн газар нутагт олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй 6 аж ахуйн нэгжийн 8 лиценз байна. Үүнд: "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 3 лиценз /Чингилийн гол, Дэлт толгойн орд, Шанд/, "Чингэлцагаан бөөн" ХХК, "Зунрун", "Очир төв" ХХК, "Борцэцэг" ХХК, Отгонтэнгэр оргил ХХК "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Очир төв" ХХК үйл ажиллагаа явуулж, бусад аж ахуйн нэгжүүд 2013 оноос хойш эдийн засгийн болон бусад шалтгаанаар үйл ажиллагаагаа явуулаагүй тул холбогдох хууль тогтоомжийн дагуу Мэргэжлийн хяналтын Улсын Байцаагчийн актаар түр хаагдсан байна. "Оны өвөлжөө" ХХК, "Ар Пи Ти" ХХК, Тэнүүн төвөргөөн ХХК, Сансарын эрин ХХК, Абуз ХХК, Гарлимимус ХХК, Сохол ХХК, Ууган гарьд групп ХХК зэрэг нь 2020, 2021 онд хайгуулын тусгай зөвшөөрөл авсан бөгөөд үйл ажиллагаа эхлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна. 2022 онд Дайрга уул ХХК, Эрдэнийн цаачир уул ХХК нь түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авсан. Орхон аймагт 2022 оны байдлаар түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл 8, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл 5, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл 10 байгаа ба тусгай



2.	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын мэдээ гаргах	Жилдээ	МХГ	Аймгийн ЗДТГ	Мэдээг тогтмол авсан байна	зөвшөөрлийг Ашигт малтмал газрын тосны газрын кадастрын системд бүгд бүртгэгдсэн байна. Хэрэгжилт 100% Мэргэжлийн хяналтын газар нь "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Очир төв ХХК-ийн 2022 оны ашигт малтмалын нөөц ашиглалтын тайланг улирал бүр авч, холбогдох газарт хугацаанд нь хүргүүлж ажилласан. Хэрэгжилт 70%
3.	Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив, дэмжлэгийн мэдээ гаргах	Улирал, жилээр	Аймгийн ЗДТГ СТСХ	Татварын хэлтэс, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ	Иргэдэд ил тод мэдээлэх ажил сайжирсан байна.	Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив, дэмжлэгийн мэдээг МОНТБААЛБанд хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудаас орон нутгийн төсөвт төлж байгаа татвар, хураамж, торгууль зэрэг орлого болон аймаг, сумын ЗДТГ, төсөвт байгууллагад хандивлаж байгаа мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийн тайланг холбогдох маягтын дагуу Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн орлого, хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн нь жил бүр гаргаж Egednet.mn д байршуулж нийтэд мэдээлж, тайлагнан ажиллаж байна Хэрэгжилт 100%
4.	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖСайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу гүйцэтгүүлж, батлуулан хэрэгжилтийг хангуулж ажиллах	Жилдээ	БОАЖГ	ХБТХОХ, МХГ, ГХБХБГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ	Байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл буурна.	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Ачит-Ихт" ХХК, "Эрдмин" ХХК, Очир төв ХХК зэрэг ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах" журмын дагуу гүйцэтгүүлэн БОАЖЯамаар батлуулан хэрэгжилтэд нь аймгийн Засаг даргын 2020 оны А/540 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хяналт тавин ажиллаж, биелэлтийг дүгнэсэн. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний

<p>Биелэлт 91.6 "Ачит-Ихт" ХХК 93.9, "Эрдмин" ХХК 91.5, Очир төв ХХК 91.4 хувиар тус тус дүгнэгдсэн. Хэрэгжилт 100%.</p>	<p>Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь Хаягдлын аж ахуйн хэсгийн ойр орчимд суурьшиж буй малтай иргэдэд үйлдвэрийн газрын Онцгой байдлын газар, Хуулийн хэлтэс, Баяжуулах үйлдвэр зэрэг бүтцийн нэгжүүдийн мэргэжилтнүүд хамтран албан шаардлага хүргүүлж мэдээллээр хангаж ажилласан.</p> <p>Мөн Хаягдлын аж ахуйн хэсгийн бүсэд Дотоодыг хамгаалах 816-р ангитай гэрээ байгуулан хөдөлгөөнт /мотоциклтой/ байнгын 2 харуулыг тогтмол ажиллуулж байна.</p> <p>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хэмжээнд хийгдсэн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнүүдийн хүрээнд тоосжилтоо бүсийн Говил, Баанцагаан багууд, Жаргалант сумын 100 гаруй иргэдийг хамруулан 4 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж, судалгааны ажлын дүгнэлт, мэдээллийг өгч, иргэдийн санал шүүмжийг авч ажилласан.</p> <p>Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг болох Баян-Өндөр уулын Хүрэнбулагийн аманд дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.</p> <p>"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ 2022 оны уулын ажлын төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө тусуулан батлуулсны дагуу 3-р отвоол дээрээ 3.9 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг гүйцэтгүүлсэн.</p> <p>Очир төв ХХК Хангал гол дагуу 500 ширхэг улиас моднуудыг 0.5га-д Зэс эрдэнийн хувь ХХК үйлдвэрийнхээ замын ногоон зурвасыг шинээр хийж 500 ширхэг улиас, 200 ширхэг шинэс</p>
	<p>Судалгааны сан бий болсон байна.</p>
	<p>-</p>
	<p>Аймгийн ЗДТГ, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд, "Эрдэнэт хүмүүний эв нэгдэл" ТББ, "Төр иргэн туншлал" ТББ, иргэд</p>
	<p>БОАЖГ, ЭМГ, МХГ, Стандарт хэмжил зүйн хэлтэс</p>
	<p>Жилдээ</p>
	<p>Уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөллийн бүсэд амьдарч байгаа айл өрх, иргэд, мал сүрэгт аюултай хог хаягдал, агаарын бохирдол, бусад нөлөөллөөс үүсч буй хор хөнөөлийн талаарх мэдээ, судалгаа гаргах</p>
<p>5.</p>	

							<p>моднуудыг тус тус тарьж арчлан ургуулж байна.</p> <p>Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудтай 2022 онд "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөн, "Ногоон Эрдэнэт" хөтөлбөрийг дэмжин оролцож "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-тай 10.0 сая, Эрдмин ХХК-тай 2.0 сая, Ачит-Ихт ХХК-тай 3.0 сая, Зэс эрдэнийг хувь ХХК-тай 1.5 сая, Гал сэнтий ХХК-тай 10000 ширхэг мод, бут, сөөгийг 2022-2030 он хүртэлх хугацаанд тус тус тарьж ургуулж хамгаалах нийгмийн хариуцлагын гэрээг байгуулж, 2022 оны хавар, намрын бүх нийгээрээ мод тарих ажлын хүрээнд Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ хаягдлын аж ахуйд хамгаалалтын ногоон зурвас хийж 4 төрлийн 936895 ширхэг навчит болон шилмүүст моднууд тарьж 50 га-д, Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг дэвсгэр дэх гурван замын ногоон зурваст Ачит-Ихт ХХК 1600 ширхэг хайлаас, Эрдмин ХХК 1000 ширхэг улиас, Гал сэнтий ХХК 1000 ширхэг улиас моднуудыг тус тус тариулж намрын цэнэг усалгаа, арчилгааг нь гүйцэтгэн нийт 66га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг гүйцэтгүүлэн ажиллалаа. Хэрэгжилт 70%</p>
Зорилт 2. Тайлан мэдээг иргэдэд нээлттэй, ил тод мэдээлэх							
7.	Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурвалжлага, мэдээ явуулах	Жилдээ	Хэвлэл мэдээллийн байгууллагуу Д. "Эрдэнэт хүмүүний эв нэгдэл" ТББ, "Төр иргэн туншлал" ТББ	Аймгийн ЗДТГ, МХГ, БОАЖГ	-	Мэдээлэл олон нийтэд хүрсэн байна.	"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, Ачит Ихт ХХК, Эрдмин ХХК нь үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг үйлдвэрийн цахим хуудас, орон нутгийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд мэдээлэл тогтмол хүргэж байна.
8.	Аймгийн ОУИТБС-ын дэд зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх	Жилдээ	Аймгийн ЗДТГ	ОУИТБС-ын дэд зөвлөл	1.5сая	Үйл ажиллагаа идэвхжиж зөвлөлийн гишүүдийн үүрэг оролцоо сайжирна.	Хэрэгжилт 100% Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн Дэд зөвлөлийн чадавхыг бэхжүүлэх, түүний үйл ажиллагаанд дэмжих зорилгоор ТББ-тай хамтран ажиллах 1.5 сая төгрөгийг тусгасан.

							<p>"Эрдэнэт Хүмүүний Эв Нэгдэл" ТББ-тай 1.5 сая төгрөгөөр хамтран ажиллах гэрээ байгуулсан. Аймгийн хэмжээнд уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшдэг болон олборлох үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн орон нутгийн засаг захиргаатай байгуулсан бүх төрлийн гэрээний хэрэгжилт, үр өгөөжийг сайжруулах, олон нийтийн хяналт оролцоог нэмэгдүүлэх, гэрээний ил тод байдлыг сайжруулж төр иргэний эргэх хариуцлагыг чанаржуулахад тухайн ТББ нь дэд зөвлөлтэй хамтран ажиллаж байна.</p> <p>Хэрэгжилт 100%</p>
<p>Зорилт 3. Хамтын ажиллагаа, түншлэл хөгжүүлэх, оролцогч талуудын чадавч бэхжүүлэх</p>							
9.	<p>Орхон аймаг, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Ачит-Ихт" ХХК, "Эрдмин" ХХК-тай байгуулсан хамтран ажиллах гэрээ, түүний хэрэгжилтийн тайланг нээлттэй тайлагнах</p>	Жилдээ	Аймгийн ЗДТГ	<p>Хэвлэл мэдээллийн байгууллагууд, "Эрдэнэт хүмүүний эв нэгдэл" ТББ, "Төр иргэн түншлэл" ТББ</p>		<p>Хамтран ажиллах гэрээнд иргэдийн зүгээс тавих хяналт, мэдээлэл сайжирч, холбогдох мэдээллээр хангагдана.</p>	<p>Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Ачит-Ихт", "Эрдмин" ХХК-тай байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр 2021-2023 онд хамтран ажиллах гэрээ байгуулсан. 2022 онд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай 3.0 тэрбум, "Эрдмин" ХХК-тай 1.1 тэрбум, "Ачит-Ихт" ХХК-тай 1.04 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй хамтран ажиллах төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Биелэлтийг жилийн эцсийн байдлаар нэгтгэж, хэрэгжилтийг дүгнэхээр ажиллаж байна.</p> <p>Гэрээ, төлөвлөгөөг эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан (www.iltodgergee.mn)-д мэдээлсэн. Хэрэгжилт 100%</p>
10.	<p>Хуульд заасан мэдээллийг үнэн зөв гаргаж нийтэд мэдээлээгүй ашигт малтмалын зөвшөөрөл эзэмшигч, тэдний гэрээт туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжид зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх</p>	Жилдээ	МХГ	Аймгийн ЗДТГ		<p>Мэдээллийг үнэн зөв мэдээлсэн байна.</p>	<p>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Очир төв" ХХК нь хуульд заасан мэдээллийг хугацаанд нь гаргаж мэдээлэн ажиллаж байна.</p> <p>Хэрэгжилт 70%</p>

11.	<p>Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутгийн төсөвт 2021 онд телж байгаа татвар, телбөр, хураамж, торгууль зэрэг орлого болон аймаг, сумын ЗДТГ, төсөвт байгууллагад хандивлаж байгаа мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийн тайланг холбогдох маягтын дагуу жил бүр гаргаж нийтэд мэдээлэх, журмын дагуу тайлагнах</p>	4-р улиралд	Аймгийн ЗДТГ СТСХ	Татварын хэлтэс, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд	Мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь мэдээлсэн байна.	<p>Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудаас орон нутгийн төсөвт телж байгаа татвар, хураамж, торгууль зэрэг орлого болон аймаг, сумын ЗДТГ, төсөвт байгууллагад хандивлаж байгаа мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийн тайланг холбогдох журам, маягтын дагуу Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн орлого, хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн нь тухай бүрт гарган ОУИТБСА албанд хүргүүлж, Egedenei.mn-д байршуулаг нийтэд мэдээлж, тайлагнан ажиллаж байна. Гэрээг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр иргэд, олон нийтэд мэдээлж, Egedenei.mn сайтад байршуулсан. Гэрээ, төлөвлөгөөг эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан (www.itodgergee.mn)-д мэдээлсэн. Хэрэгжилт 100%</p>
12.	<p>Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, дэд зөвлөлийг чадаажуулах сургалт зохион байгуулах</p>	Жилдээ	Аймгийн ЗДТГ	МХГ, БОАЖГ	<p>1.0 /ОУИТБСА/</p> <p>Үйл ажиллагааны хяналт сайжирна.</p>	<p>ОУИТБСА-наас олгосон 1сая төгрөгөөр ажлын хэсэг уул уурхайн компанийн үйл ажиллагаатай танилцсан ба мөн Аймгийн ОУИТБС-ын дэд ажлын хэсэг 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр аймгийн хэмжээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй болон түгээмэл тархацтай ашигт малтмалыг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн орон нутгийн засаг захиргаатай байгуулсан бүх төрлийн гэрээний хэрэгжилт, үр өгөөжийг сайжруулах, олон нийтийн хяналт оролцоог нэмэгдүүлэх, гэрээний ил тод байдлыг сайжруулж төр иргэний эргэх хариуцлагыг талаар сургалтыг зохион байгууллаа. Сургалтад Ачит Ихт ХХК, Эрмин ХХК, Гал сэнтий ХХК, Зэс эрдэний хувь ХХК болон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй зарим аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон. Сургалтаар "Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлт, орон нутгийн оролцоо, хяналт", "Тусгай зөвшөөрөл олголт ба орон нутгийн</p>

<p>оролцоо, тулгамдсан асуудал, Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын нээлттэй мэдээллийг орон нутгийн удирдлага, иргэний нийгмийн байгууллага хэрхэн бодлого шийдвэртээ ашиглах вэ талаар илтэл танилцуулж хэлэлцүүлэг хийсэн.</p> <p>Тайланг хугацаанд нь ОУИТБСА-нд хүргүүлсэн.</p> <p>Хэрэгжилт 100%</p>																																	
<p>13.</p>	<p>Жил бүрийн ажлын төлөвлөгөө, тайланг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын албанд хүргүүлэх</p>	<p>Жилдээ</p>	<p>Аймгийн ЗДТТ</p>	<p>ОУИТБС-ын дэд зөвлөл</p>	<p>-</p>	<p>Төлөвлөгөө, тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна.</p>																											
<p>ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ</p>																																	
<p>ТАНИЛЦСАН: ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА</p>																																	
																																	
<p>ТАЙЛАГНАСАН: ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН</p>																																	
																																	
<p>У.ЧИГЭСЭЙ</p>																																	
<p>93.1%</p>																																	